



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 23 өдөр

Дугаар А/266


Булган сум

“Бүлгийн удирдагч” бэлтгэх сургалтад
аймгийн скаутын бүлгэмийн гишүүдийг оролцоход
хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.3, 66 дугаар зүйлийн 66.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIX хуралдааны “Булган аймгийн 2024 оны төсөв батлах тухай” XIX/08 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2024 оны А/32 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Олон улсын хүүхдийн найрамдал зусланд зохион байгуулагдах “Бүлгийн удирдагч” бэлтгэх сургалтад аймгийн скаутын бүлгэмийн гишүүдийг оролцуулсугай.

2. Сургалтад оролцоход шаардагдах 1,365,000 (нэг сая гурван зуун жаран таван мянга) төгрөгийг Хүүхэд хамгааллын хөтөлбөрөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.



ЗАСАГ ДАРГА

БАРИУН-ЭРДЭНЭ

Аймгийн Засаг даргын 2024 оны
04 дүгээр сарын 23-ний өдрийн 7/266 дугаар
захирамжийн хавсралт

АЙМГИЙН СКАУТЫН БҮЛГЭМИЙН ГИШҮҮДИЙГ ЧАДАВХЖУУЛАХ
СУРГАЛТАД ШААРДАГДАХ ТӨСӨВ

д/д	Шаардагдах зардал	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	2	3	4	5
1	Сургалтад хамрагдах гишүүд	5	195,000	975,000
2	Хариуцах багш	1	390,000	390,000
	Нийт дүн		1,365,000	

-----oOo-----